




Эрчим хүчний сайдын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны
өдрийн 11 дугаар тушаалын 11 дүгээр хавсралт



№ 11.1.11 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ
СТАНЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:

Шаардлага хангасан
асуултын тоо:

Хууль сахин
мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй
нийт оноо:

Эрсдэл үүсэх
магадлалын хувь:

Эрсдэл үүсэх
магадлал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
Техникийн баримт бичиг			0	660	0	0
1	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1	Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авсан.	0	30		
2	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1	Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг байршуулах зориулалтаар олгосон газрыг эзэмших эрхийн гэрчилгээтэй.	0	10		
3	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2	Ашиглагдаж хугацаа нь дууссан зай хураагуурыг дахин боловсруулах, устгах төлөвлөгөөтэй.	0	20		
4	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4	Техник, тоног төхөөрөмж, барилга байгууламж нь олон улсын болон үндэсний стандартыг хангаж байгаа тухай эрх бүхий байгууллагын дүгнэлттэй.	0	30		
5	Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.11 дэх заалт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн.	0	20		
6	Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.11 дэх заалт	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, мөрддөг.	0	20		

7	Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.12	Холбогдох дүрэм, журам, норм, стандарт, тусгай зөвшөөрөлийн нөхцөл, шаардлагыг хангаж ажилладаг.	0	30		
8		Үйл ажиллагаагаа технологийн горимын дагуу осол аюулгүй явуулдаг.	0	30		
9	Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1	Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай.	0	30		
10	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.2.5	Шинээр ашиглалтад орох тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авахаас өмнө ашиглалтын ба засварын хүмүүсийг бүрдүүлж сургалт явуулан, мэдлэгийн шалгалт авч ажиллах эрх олгосон байдал ба ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааврууд, шуурхай ажиллагааны схемүүд, тооцоо ба тайланд шаардагдах техникийн бичиг баримтуудын жагсаалтыг гарган баталгаажуулдаг.	0	20		
11	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.2.12	Ашиглалтад оруулах улсын комисс хүлээн авсан.	0	20		
12	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.2.14	Шинээр ашиглалтад орсон тоног төхөөрөмжийг хүлээн авсан бүх баримт бичгүүд нь улсын комиссын актын хамт захиалагчийн техникийн архивт хадгалагддаг.	0	10		
13	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.3.1	Байгууллагын ажилчин, ИТА нар нь эрхэлсэн албан тушаалдаа тохирох боловсрол ба мэргэжил эзэмшсэн бэлтгэгдсэн хүмүүстэй.	0	10		
14	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.3.6	Ажлын байран дахь ажиллагсдын ажлын сургалтыг албан тушаал, ажлын байр тус бүрд нь зориулан боловсруулж ерөнхий инженерээр баталгаажуулсан хөтөлбөртэй.	0	10		
15	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.3.14	Ажилчин, инженер техникийн ажилтан бүрийн заавал мэдсэн байвал зохих дүрэм заавруудын тухай үйлдвэрийн даргын баталсан албан тушаалын заавар /ажлын байрны тодорхойлолт/ бүрт тодорхой тусгасан.	0	10		

16	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.4.4	Эрчим хүчийг хэмнэх, цахилгаан эрчим хүчний алдагдлыг багасгах, тоног төхөөрөмжийн найдвартай, хэмнэлттэй ажиллагааг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлдэг.	0	10		
17	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.5.4	Ээлжит үзлэгийн графикийг үйлдвэрийн ерөнхий инженерээр батлуулж, мөрдөж ажилладаг.	0	10		
18	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.5.5	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, тэдгээрийн зогсолт, тасралт, эвдрэл гэмтлийг бүртгэн, шалтгааныг тодорхойлох, тоноглолын ашиглалт засварын баримтыг бүрдүүлж хөтөлдөг.	0	10		
19	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.1 заалт	Байгууллагын ашиглалтад байгаа тоног төхөөрөмж, байгууламжийн техникийн паспортууд нь үйлдвэрийн даргын томилсон хариуцагч нарт хадгалагдаж, ашиглалтын баримт тэмдэглэлээр тасралтгүй баяжигдан хөтлөгддөг.	0	10		
20	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.2	Байгууллагын нэгж хэсгүүд, бүх ажлын байруудад заавал байвал зохих заавар, технологийн схемүүдийн жагсаалт, түүний дагуу заавар схемүүдийг боловсруулж, ерөнхий инженерээр батлуулан, ажлын байруудад тавьсан.	0	10		
21	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.16	Эрчим хүчний үйлдвэр, байгууллагын үйл ажиллагаанд технологийн зөрчил /аваар саатал, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, тасралт/ гарах тухай бүр салбарын дээд байгууллагаас батлан гаргасан журам, зааврын дагуу судлах, бүртгэх, акт тогтоох ажлыг зохион байгуулдаг.	0	10		
22	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.5.3	Эрчим хүчний үйлдвэр, байгууллагууд нь дээд байгууллагын үлгэрчилсэн зааврын дагуу аваарын нөөц бүрдүүлсэн.	0	20		
23	ТХШТХ-ийн 7.2, Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 2011 оны 311 тогтоол	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг.	0	10		
24		Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтантай.	0	10		

Генератор ба синхрон компенсатор			0	130		
25	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.1.1 дэх заалт	Генератор ба синхрон компенсаторын ашиглалтын үед тэдгээрийн зохистой горим дахь тасралтгүй ажиллагаа хангагдаж, өдөөлт, хөргөлт, тос хангамжийн системүүд болон, автоматик хамгаалалт ба хяналт оношлолын байгууламжууд нь найдвартай ажилладаг.	0	20		
26	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.1.5 дахь заалт	Роторын хэлхээг тасалж соронзон орныг унтраах автоматаар тоноглогдсон генераторуудад хэт хүчдэлээс хамгаалах тусгай хамгаалалт тавигдсан, тэр нь байнга ажилладаг.	0	20		
27	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.1.8 дахь заалт	Генератор ба синхрон компенсаторын гал унтраах байгууламжийг цаг ямагт ажиллагааны бэлэн байдалд байлгаж, шаардлага гармагц ажиллаж эхлэх нөхцөлийг хангасан.	0	10		
28	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.1.9 дэх заалт	Генератор ба синхрон компенсаторыг явуулах ба ашиглалтын үед тавих байнгын хяналтыг зохион байгуулдаг.	0	10		
29	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.1.10 дахь заалт	Ажиллагаанд буюу бэлтгэлд байгаа генератор ба синхрон компенсаторын хий тосны ба усан системийн ажиллагааны үзүүлэлтүүдэд энэ дүрэмд нийцүүлэн хяналт шалгалтыг хийдэг.	0	10		
30	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.1.34 дэх заалт	Турбогенераторын холхивч ба голын нягтруулга, агаарын хөргөлттэй синхрон компенсаторын холхивч, усан генераторын холхивч ба ивүүрийн хөндийрүүлгийг сард нэгээс доошгүй шалгадаг.	0	10		
31	Ашиглалтын заавар	Генераторын холхивчуудын халалтын хэм шаардлагатай хэмжээнд байдаг.	0	10		
32	Ашиглалтын заавар	Генераторын доргилт чичиргээний түвшин стандартын хэмжээнд байдаг.	0	20		
33	Эрчим хүчний сайдын 2020 оны 159 дүгээр тушаалын хавсралт 1.2.6.	Цэнэг хуримтлуурын төхөөрөмжгүй үүсгүүрийн хувьд цахилгаан түгээх сүлжээ рүү холбогдсон цэгт сүлжээ талаас хүчдэлгүй болмогц үүсгүүрийн үйл ажиллагаа бүрэн зогсох буюу гэдрэг хүчдэл өгөхгүй байх техникийн шаардлагыг бүрдүүлсэн.	0	20		

Цахилгаан хөдөлгүүр			0	120		
34	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.1 дэх заалт	Цахилгаан хөдөлгүүр, түүний явуулах тохируулах байгууламж ба хамгаалалт нь хөдөлгүүрийг явуулах ба ажлын горимд найдвартай ажилладаг.	0	20		
35	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.3 дахь заалт	Цахилгаан хөдөлгүүр ба түүнд холбогдох механизм дээр эргэх чиглэлийг нь сумаар зааж тэмдэглэсэн, цахилгаан хөдөлгүүр ба түүний явуулах байгууламж дээр ямар механизмыг хөдөлгөхөд зориулагдсаныг бичсэн.	0	10		
36	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.4 дэх заалт	Тоостой ба их чийгтэй байранд суурилагдсан үлээлэгтэй цахилгаан хөдөлгүүрийг хөргөлтийн цэвэр агаар өгөх байгууламжаар тоноглогсон байх бөгөөд, түүний температур нь зааварт заагдсан шаардлагыг хангасан.	0	10		
37	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.6 дахь заалт	Холхивч нь албадлагын тосолгооны системтэй цахилгаан хөдөлгүүрт тосны урсгал тасалдахад болон хариуцлагатай чухал хөдөлгүүрийн холхивчийн температур зөвшөөрөгдөх хэмжээнээс ихсэхэд дохиолол өгөх хэрэгсэл ба хөдөлгүүрийг зогсоох үйлчилгээтэй хамгаалалт тавигдсан.	0	20		
38	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.7 дахь заалт	Хариуцлагатай чухал механизмын нэрсийн жагсаалтыг станцын ерөнхий инженер баталсан.	0	10		
39	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.9 дэх заалт	Бэлтгэлд удаан хугацаагаар зогсож байгаа хөдөлгүүрийг ерөнхий инженерээр батлагдсан графикийн дагуу механизмын хамт явуулж шалгадаг.	0	10		
40	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.9 дэх заалт	Хэрэв хөдөлгүүр нь гадаа байрласан бөгөөд халаалтгүй бол, явуулж туршихын өмнө статорын ороомгийн хөндийрүүлгийн эсэргүүцэл ба абсорбц /чийг шингээлт/-ийн коэффициентийг шалгасан.	0	10		
41	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.10 дахь заалт	Хариуцлагатай чухал механизмуудын доргиог ерөнхий инженерийн баталсан графикт хугацаанд хэмждэг.	0	10		
42	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.2.16 дахь заалт	Цахилгаан хөдөлгүүрт урьдчилан сэргийлэх туршилт ба хэмжилт хийх ажлыг "Цахилгаан тоноглолд туршилт хийх норм"-н дагуу хийж гүйцэтгэдэг.	0	20		

Хүчний трансформаторууд ба тосны реакторууд			0	140		
43	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.1 дэх заалт	Ачаалал, хүчдэл, тосны температурыг тогтсон норм хэмжээнд барьж ажилладаг, хөндийрүүлэгч ба тосны үзүүлэлтүүдийг норм хэмжээнд, хөргөлт, хүчдэлийн тохируулга, тосны хамгаалалтын байгууламжуудыг бүрэн бүтэн байлгадаг.	0	20		
44	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.5 дахь заалт	Трансформаторууд, (реактор)-ын хөргөлтийн байгууламжийн цахилгаан хөдөлгүүрүүд нь тэжээлийн хоёр эх үүсвэртэй байх тосны албадмал хөргөлттэй бол АВР-тэй.	0	20		
45	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.7 дахь заалт	Трансформаторын дэд станц ба камерын салхижуулалт нь нормчлогдох бүх горимд трансформаторын хэвийн ажиллагааг хангасан.	0	10		
46	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.8, 5.3.9, 5.3.10 дахь заалтууд	Трансформаторын агаар ба тосны албадмал эргэлт салхилуурын болон усан хөргөлтийн системийн ажиллагаа нь ТАД-ийн шаардлагыг хангасан.	0	20		
47	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.11, 5.3.12 дахь заалтууд	Ажиллаагүй байгаа болон ажиллагаанд байгаа трансформатор (реактор)-уудын тэлэгч дэх тосны түвшин нь трансформатор (реактор)-ын тосны температурт тохирох заалт дээр байдаг.	0	10		
48	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.15 дахь заалт	Аваарын горимуудад трансформаторуудыг урьд ачаалал, хөргөлтийг системийн төрлүүд, орчны температур зэргийг харгалзахгүйгээр хэт ачаалж байгаа нь энэ дүрмийн заалттай нийцдэг.	0	10		
49	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.26 дахь заалт	Трансформаторын гадна үзлэгийг тогтмол хийдэг.	0	10		
50	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.27, 5.3.28 дахь заалтууд	Трансформатор, /реактор/ -ын их болон урсгал засвар, туршилтыг тогтоосон хугацаанд норм зааврын дагуу хийдэг.	0	20		
51	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.3.29 дэх заалтууд	Трансформатор /реактор/-т урьдчилан сэргийлэх туршилтыг "Цахилгаан тоноглолын туршилтын норм" ба зааврын дагуу хийдэг.	0	20		

Хуваарилах байгууламж			0	210		
52	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.1 дэх заалт	ХБ-д үйлчилдэг хүмүүс нь цахилгаан тоноглолуудын хэвийн ба аваарын нөхцөлд ажиллах зөвшөөрөгдөх горимыг тусгасан схем ба заавруудаар хангагдсан.	0	10		
53	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.2 дахь заалт	Хэт хүчдэлээс хамгаалах байгууламж нь цахилгаан тоноглолын хөндийрүүлгийн түвшинд тохирсон.	0	10		
		Хаалттай болон ил ХБ-ийн цахилгаан тоноглол, тэдгээрийн хөндийрүүлэгчийн гадаргуугийн бохирдол хэвийн.	0	10		
54	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.3, 5.4.4 дахь заалтууд	Хаалттай болон иж бүрэн ХБ-ийн дотор агаарын хэм тогтоогдсон хэмжээнд байдаг, битүүжлэл дүрмийн шаардлага хангасан.	0	20		
55	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.5 дахь заалт	Хуваарилах байгууламжийн гүйдэл дамжуулах хэсгүүд ургаа мод, гаднын болон байгалийн биетээс зохих зайд байрласан.	0	10		
	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.6 дахь заалт	Ил ба ХХБ-ийн кабелийн суваг нь галд тэсвэртэй хавтангаар тагласан, кабелийн сувгаас гарч байгаа хэсэг хоорондын нүх сүв, кабелийн тусгаарлагдсан хэсгүүдийг галд тэсвэртэй материалаар чигжиж тусгаарласан, хонгил, зоорь, сувгууд нь байнга цэвэрхэн, ус зайлуулах байгууламж нь бүрэн ажиллагаанд бэлэн байдаг.	0	20		
56	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.7 дахь заалт	Тос хүлээн авагч, хайрган дэвсгэр, дренаж ба тос зайлуулах хоолойны бүрэн бүтэн.	0	10		
57	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.10 дахь заалт	3 кВ ба түүнээс дээш хүчдэлийн хуваарилах байгууламжууд нь салгуур, тусгаарлагч, богино залгагч, (КРУ)-ийн тэргэнцэр зэрэг нь газардуулагч хутгаар буруу үйлдэл хийхээс сэргийлэх хоригийн төхөөрөмжөөр тоноглогдсон.	0	20		
	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.12 дахь заалт	3 кВ ба түүнээс дээш хүчдэлийн хуваарилах байгууламжид газардуулга тавихад байнгын газардуулгын хутгыг ашиглаж байгаа эсэх. Газардуулагчийн бариулыг улаан, хутгыг нь хар өнгөөр будсан.	0	20		
58	Нэгдсэн сүлжээний дүрэм 1.3.3.3 дахь заалт	ХБ-ийн бүх цахилгаан тоноглол дээрх шуурхай ажиллагааны хаяг нь дүрмийн заалтыг хангасан.	0	10		

59	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.15 дахь заалт	Хуваарилах байгууламжийг сүлжээнээс таслахгүйгээр тоног төхөөрөмжид нь дараах байдлаар үзлэг хийдэг. Үүнд: Байнгын жижүүртэй бол: Хоногт 1-ээс доошгүй удаа, Харанхуйд хийх цахилгаан цэнэгийн нэвчилт, цахилгалтыг шалгах үзлэгийг сард 1-ээс доошгүй удаа. Байнгын жижүүргүй бол : Сард 1-ээс доошгүй удаа, Трансформаторын ба хуваарилах пунктад 3 сард 1-ээс доошгүй удаа.	0	10		
	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.16 дахь заалт	Хуваарилах байгууламжид суурилагдсан анхдагч болон хоёрдогч хэлхээний тоног төхөөрөмжүүд нь цахилгаан халаагуураар бүрэн хангагдсан ажиллагаатай.	0	10		
60	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.20 дахь заалт	ХБ-ийн таслуур, хуурай салгуур ба газардуулагч хутга, ачаалал таслагч, тусгаарлагч, богино холбогч зэрэг тоноглолын засварыг заасан хугацаанд хийдэг. /Урсгал засварыг тухайн үйлдвэрийн ерөнхий инженерийн тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ./	0	10		
61	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.4.21 дэх заалт	ХБ-ийн цахилгаан тоноглолуудыг "Цахилгаан тоноглолын туршилтын норм"-ын дагуу туршигдсан.	0	20		
	Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм БД 43-101-03-ын 1.6.31 дэх заалт	ХБ-ийн Газардуулгын байгууламжид эсэргүүцлээр тавигдах шаардлага нь жилийн ямар ч улиралд 0,5 Ом-оос хэтрэхгүй байна.		20		
Цахилгаан дамжуулах агаарын шугам			0	110		
62	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.1 дэх заалт	ЦДАШ-ын ашиглалтын явцад түүний найдвартай ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн үйлчилгээ, засвар хийгдсэн.	0	10		
63	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.5 дахь заалт	ЦДАШ-ын эд ангиудыг хугацаанаасаа өмнө элэгдэхээр урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт, хэмжилт хийх, илэрсэн гэмтэл зөрчлийг арилгах зэрэг техникийн үйлчилгээ хийгдсэн.	0	10		

64	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.10 дахь заалт	Агаарын шугам дагуу тогтоосон өргөнтэй газрын бут сөөг, модыг тогтмол тайрч цэвэрлэж гал түймрийн аюулгүй байдлыг хангасан.	0	10		
65	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.11 дэх заалт	Шувуу олноор үүрлэж, хөндийрүүлэгчийг их бохирдуулдаг бүсэд шувууг үргээх буюу хөндийрүүлэгч дээр суулгахгүй байх тусгай хэрэгсэл төхөөрөмж ашигладаг.	0	10		
66	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.13 дахь заалт	Агаарын ЦДШ-д зураг төсөл, техникийн нормативын дагуу шугамын тулгуурууд дээр тавигдсан тэмдэг, дохиолол, санамжуудбүрэн тавигдсан.	0	10		
67	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.15 дахь заалт	Ерөнхий инженерийн баталсан ээлжит үзлэгийн графиктай. ИТА-ууд жилд нэгээс доошгүй удаа түүвэрчилсэн үзлэг зохион байгуулсан эсэх /үг үзлэгт их засвар хийгдэх хэсгүүд хамрагдсан байх ёстой./	0	10		
68	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.17 дахь заалт	Агаарын шугамын урьдчилан сэргийлэх үзлэг ба хэмжилтүүд хийгдсэн.	0	10		
69	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.18 дахь заалт	Агаарын шугамд үзлэг хийх, урьдчилан сэргийлэх шалгалт, хэмжилт хийхэд илэрсэн дутагдлуудыг ашиглалтын баримт материалд тэмдэглэж тэдгээрийн үзүүлэх нөлөөллийг харгалзан ноцтойг нь яаралтай арилгах, бусдыг нь техникийн үйлчилгээ буюу их засвар хийх үед устгах ажил хийгддэг.	0	20		
70	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.19, 5.7.9 дахь заалтууд	Төмөр ба төмөр бетон тулгууртай агаарын шугамын их засвар ба зэврэлтээс хамгаалах арга хэмжээг энэ дүрмийн хүрээнд хийгдсэн.	0	10		
71	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.7.25 дахь заалт	Цахилгаан дамжуулах агаарын шугамд гарсан аваарыг цаг хугацаанд нь устгахын тулд тогтоосон нормын дагуу сэлбэг материалын аваарын нөөц бүрдүүлсэн.		10		
Хүчний кабелийн шугам			0	70		
72	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.8.10 дахь заалт	Кабель шугам бүр шугамын үндсэн үзүүлэлтүүдийг заасан паспорт мөн тус дүрмийн 5.8.8-д заасан бичиг баримтыг агуулсан архивын хувийн хэрэг хөтөлдөг.	0	10		

73	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.8.10 дахь заалт	Пайзыг орчны агаарын нөлөөлөлд тэсвэртэй материалаар хийнэ. Ил татагдсан кабельд пайзыг 50м тутамд зүүхээс гадна булан тохой гарсан, хаалт ханыг нэвтлэн гарсан газруудын 2 талд шугамын эхэн ба эцэст пайз зүүсэн.	0	10		
74	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.8.13 дахь заалт	Үзлэгийн үеэр илэрсэн гэмтэл дутагдлын талаар гэмтлийн журналд бичиж, зөрчлийг яаралтай арилгах арга хэмжээ авдаг.	0	20		
75	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.8.14 дэх заалт	Байнгын дежуртэй дэд станц, цахилгаан станцын кабелийн давхрууд, сувгууд, худаг, туннелиудийн үзлэгийг сард 1-ээс доошгүй, байнгын дежургүй станц, дэд станцад байгууллагын ерөнхий инженерийн тогтоосон хугацаанд явуулдаг.	0	10		
76	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.8.18 дахь заалт	Цахилгаан, хөрс, химийн зэврэлтээс кабелийн металл бүрхүүл гэмтэх байдал илэрсэн тохиолдолд түүнээс хамгаалах арга хэмжээ авдаг.		20		
Газардуулгын байгууламж			0	90		
77	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.1 дэх заалт	Газардуулагч байгууламж нь хүмүүсийн цахилгааны аюулгүй байдлыг хангах, цахилгаан тоноглолыг хамгаалах ба ажлын ашиглалтын горимын шаардлагуудыг хангасан.	0	20		
78	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.1 дэх заалт	Хөндийрүүлэг алдагдсаны улмаас хүчдэлтэй болж болох цахилгаан тоноглолуудын ба цахилгаан төхөөрөмжүүдийн бүх металл хэсгүүдийг газардуулагдсан буюу "ноль"-туулагдсан.	0	20		
79	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.3 дахь заалт	Төхөөрөмжийн хэсэг бүр тусдаа газардуулгын утсаар газардуулагч байгууламжид холбогдсон.	0	10		
80	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.5 дахь заалт	Газардуулгын дамжуулагчдыг зэврэлтээс хамгаалсан байх ба ил дамжуулагчид хараар будсан.	0	10		
81	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.6 дахь заалт	Газардуулах байгууламжийг зэврэлтээс хамгаалсан, хэмжилт хийгдсэн. /Газардуулгын байгууламжийн хоорондын холболтын байдлыг 12 жилд нэгээс доошгүй удаа шалгах, /	0	10		

82	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.7 дахь заалт	Газардуулах байгууламжийн эсэргүүцлийг тогтоосон хугацаанд хэмждэг. / Олон жилийн графиктай эсэх /	0	10		
83	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.10.10 дахь заалт	Ашиглалтад байгаа газардуулгын байгууламж бүрэн түүний схем, техникийн үндсэн өгөгдлүүд, үзлэг шалгалтын үр дүн, үндсэн засвар өөрчлөлтийн шинж чанар болон бусад өгөгдлүүдийг тусгасан паспорттай.		10		
Диспетчерийн шуурхай удирдлага			0	180		
84	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.3.19 дэх заалт	Улирал тутамд аваар эсэргүүцэх дасгал хийдэг.	0	10		
85	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.2 дахь заалт	Нэгдсэн сүлжээний хэмжээнд мөрдөгдөх зааврууд нь Диспетчерийн үндэсний төвд танилцуулж, зөвшөөрөл авсан.	0	20		
86	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 1.7.18 дахь заалт	Ерөнхий удирдах щитүүд нь аваарын ба онцгой үед, шуурхай ажиллагааны хүмүүсийн харилцан яриаг бичиж тэмдэглэх холбооны автомат соронзон бичлэгийн системээр тоноглогдсон.	0	10		
87	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.1.8 дахь заалт	Байгууллага, үйлдвэр бүрийн диспетчерийн шуурхай удирдлагад болон мэдэлд байгаа цахилгаан дамжуулах шугам, дулааны шугам, тоноглол болон байгууламжуудын жагсаалтыг боловсруулж батлуулсан.	0	10		
88	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.1.10 дахь заалт	Диспетчерийн шуурхай удирдлагыг диспетчерийн ба технологийн удирдлагын хэрэгсэл болон хяналтын системээр тоноглогдсон, шуурхай ажиллагааны схемээр хангагдсан диспетчерийн төв буюу щитнээс гүйцэтгэдэг.	0	20		
89	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.1.11 дэх заалт	Шуурхай ажиллагааны яриа ба бичлэг хийх журамтай.	0	10		
90		Сэлгэн залгалт хийх заавартай.	0	10		
91		Аваар устгах заавартай.	0	10		
92	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.6.4 дэх заалт	Цахилгаан сүлжээ, дэд станц болон цахилгаан станцын хэвийн ба засварын холболтын схемийг жил бүр тухайн үйлдвэрийн ерөнхий инженер баталсан.	0	10		

93	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.7.7 дахь заалт	Шуурхай ажиллагааны хүмүүс нь шийдвэр буюу зөвшөөрөл өгсөн, авсан тухайгаа шуурхай ажиллагааны журналд тэмдэглэдэг.	0	10		
94	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.8.4 дэх заалт	Шуурхай ажиллагааны сэлгэн залгалтын бланк, хөтөлбөрт цахилгаан тоноглолын холболтын схем болон РХА-ын хэлхээнд сэлгэн залгалт хийх үйлдлүүдийн дарааллыг тогтоосон, элгэн залгалтыг гардан гүйцэтгэгч нь сэлгэн залгалтын бланкыг бичиж, хянуулсан.	0	10		
95	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.8.13 дэх заалт	Ерөнхий инженерээр батлуулсан шуурхай ажиллагааны сэлгэн залгалтын үед оролцох эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалттай.	0	10		
96	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 6.8.14 дэх заалт	Диспетчерийн удирдлагаас гадна байдаг 35 кВ ба түүнээс доош хүчдэлтэй хуваарилах шугам сүлжээний сэлгэн залгалтыг инженер техникийн удирдах ажилтан (Салбарын дарга, мастер)-ын шийдвэрээр гүйцэтгэж болно. Ийм сэлгэн залгалт хийгдэж байх объектуудын нэрсийн жагсаалт, сэлгэн залгалт хийх журмыг техникийн удирдлагаар батлуулсан.	0	10		
97	Нэгдсэн сүлжээний дүрэм 13.1.4 дэх заалт	Технологийн зөрчил гаргахад хүргэсэн шалтгаан, судлах явцад илэрсэн дутагдлыг бүрэн арилгах, давтан гаргуулахгүй байх талаар акт, удирдамж материалд төлөвлөгдсөн арга хэмжээг биелүүлдэг.	0	20		
98	Нэгдсэн сүлжээний дүрэм 13.7.5 дахь заалт	ТЗЭ нар технологийн зөрчлийн талаарх сар бүрийн мэдээг дараа сарын 5-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад мэдээлдэг.	0	10		
Аккумуляторын ашиглалт			0	160	0	0
99	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.5.1 дэх заалт	Аккумуляторын төхөөрөмжийн ашиглалт нь түүнийг найдвартай, удаан хугацаанд ашиглах болон аваарын ба хэвийн горимд тогтмол гүйдлийн шин дээр хүчдэлийг зохих түвшинд барих нөхцлийг хангадаг.	0	20		
100	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.5.5 дахь заалт	1-2 жилд 1 удаа батарейний бодит багтаамжийг тодорхойлох /хэвийн багтаамжийн хязгаарт/ зорилгоор хяналтын цэнэг шавхалт хийдэг.	0	10		

101	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.5.14 дэх заалт	Аккумуляторын батарейн байрны хаалган дээр "Аккумуляторын өрөө", "Галын аюултай", Галтай орохыг хориглоно", "Тамхи татаж болохгүй" гэсэн санамжууд бичигдсэн.	0	10		
102	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.5.15 дахь заалт	Аккумуляторын батарейд ерөнхий инженерийн баталсан графикийн дагуу үзлэг хийх ёстой. Элемент бүрийн хүчдэл, цахилгаан уусмалын температур ба нягтыг сард 1-ээс доошгүй удаа хэмждэг.	0	10		
103	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм 5.5.16 дахь заалт	Аккумуляторын төхөөрөмжийн үйлчилгээг тусгайлан сургасан /мэргэшил хавсран/ цахилгааны монтёр хариуцдаг.	0	20		
104		Аккумуляторын төхөөрөмж бүр журналтай байх бөгөөд түүнд үзлэгийн дүн ба хийгдсэн ажлыг тэмдэглэдэг.	0	10		
105	Ашиглалтын заавар	Эгнээ хоорондын зай 800 мм-ээс доошгүй, захын эгнээ, хана хоёрын хоорондын зай 500 мм-ээс доошгүй байна.	0	10		
106	Ашиглалтын заавар	Аккумуляторуудыг нарны шууд туяанаас хамгаалж цонхны шилийг цагаан саарал будгаар будсан.	0	10		
107	Ашиглалтын заавар	Аккумуляторуудын өвөл, зуны горим ажиллагааг хангасан. (халаалт, салхивч)	0	10		
108	Ашиглалтын заавар	Аккумуляторуудын өрөөний хана, шалыг шаазан хавтанцараар өнгөлсөн.	0	10		
109	Ашиглалтын заавар	Ажиллагсдыг аккумулятор дээр ажиллах арга барилд мэргэжил хавсарган тусгайлан сургасан.	0	10		
110	Ашиглалтын заавар	Хүчдэл, электролитын нягт, температурыг элемент нэг бүрээр хэмждэг.	0	10		
111	Ашиглалтын заавар	Аккумуляторуудын хүчдэлийн хэмжээ тогтоосон хэмжээнд байдаг.	0	10		
112	Ашиглалтын заавар	Цэнэг хураагуурт үйлчилгээ хийдэг.	0	10		
Инвертерийн ашиглалт			0	120	0	0
113	Ашиглалтын заавар	Инвертерийн хүчдэл стандартын хэмжээнд байдаг.	0	20		
114	Ашиглалтын заавар	Инвертерд засвар үйлчилгээ хийхдээ ажлын байр бэлтгэж нарыдаар гүйцэтгэдэг.	0	20		
115	Ашиглалтын заавар	Тусгайлан сургасан, мэргэжлийн хүмүүс инвертер дээр ажилладаг.	0	20		
116	Ашиглалтын заавар	Инвертерийн гаргалгааны фазын ачааллууд тэнцүү байдаг.	0	20		
117	Ашиглалтын заавар	Инвертерийг байрлуусан тасалгаан нь хуурай, салхивчийн системтэй.	0	10		

118	Ашиглалтын заавар	Инвертерийн гэрийг газардуулгын хүрээнд холбосон.	0	20		
119	Ашиглалтын заавар	Инвертер нь байнгын хөргөлттэй тул хөргөлтийн сувгуудыг хананаас 20 см-ээс багагүй зайтай байрлуулдаг.	0	10		
Мэдээлэл-хяналтын системийн ашиглалт			0	20	0	0
120	Ашиглалтын заавар	Мэдээлэл-хяналтын кабелиуд, компьютер, салхины хурдны болон чиглэлийн мэдрүүлүүдийн ашиглалтад тэдгээрийн найдвартай ажиллагааг хангахад чиглэсэн засвар-үйлчилгээг хийдэг.	0	10		
121	Ашиглалтын заавар	Мэдээлэл-хяналтын кабелиуд, компьютер, салхины хурдны болон чиглэлийн мэдрүүлүүдийн ашиглалтын заавартай.	0	10		
Операторын байр хашааны ашиглалт			0	50	0	0
122	Ашиглалтын заавар	Операторын байр, хашааны бүрэн бүтэн байдаг.	0	10		
123	Ашиглалтын заавар	Барилгын хана, хучилт, суурь зэрэг үндсэн хийцэд ан цав, хэв гажилт, суулт үүсээгүй.	0	20		
124	Ашиглалтын заавар	Операторын байранд галын хоруудыг байрлуулж хорыг зааврын дагуу ашигладаг.	0	20		
Усан цахилгаан станцын ашиглалт			0	140	0	0
125	Ашиглалтын заавар	Усан цахилгаан станцын ашиглалт, засвар үйлчилгээний график биелэгддэг.	0	20		
126	Ашиглалтын заавар	Ус хүлээн авах байгууламжаас ус шүүрдэггүй.	0	30		
127	Ашиглалтын заавар	Усан санд хуримтлагдсан лагийг авч цэвэрлэсэн.	0	20		
128	Ашиглалтын заавар	Турбин генераторын доргилт чичиргээний түвшин стандартын хэмжээнд байдаг.	0	20		
129	Ашиглалтын заавар	Турбин генераторын холхивчуудын халалтын хэм шаардлагатай хэмжээнд байдаг.	0	20		
130	Ашиглалтын заавар	Устай харилцан үйлчлэх даралтат сав, шугам хоолойг зэвэрдэггүй ган хоолойгоор хийсэн.	0	10		
131	Ашиглалтын заавар	Далаангийн хатуу цэгүүдэд хэмжилт хийдэг.	0	20		
Салхин цахилгаан үүсгүүрийн ашиглалт			0	230	0	0
132	Ашиглалтын заавар	Салхин станцын ашиглалт, засвар үйлчилгээний график биелэгддэг.	0	20		
133	Ашиглалтын заавар	Салхин турбины дуу чимээ, чичиргээ нь стандартын хэмжээнд байдаг.	0	30		
134	Ашиглалтын заавар	Салхин турбины тулгуурт ямар нэгэн муруйлт, хэв гажилтгүй.	0	20		
135	Ашиглалтын заавар	СЦҮ-үүд нь цаг агаарын онц аюултай буюу салхины хурд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх үед технологийн хамгаалалтаар зогсдог.	0	20		

136	Ашиглалтын заавар	СЦҮ-г санамсаргүй байдлаар алсаас болон байрнаас ажилд залгахаас сэргийлсэн хоригийн системтээр тоноглогдсон.	0	20		
137	Ашиглалтын заавар	СЦҮ-н тоноглол дээр гарсан гэмтэлийн тайлбар мэдээлэл нь хяналт удирдлагын систем дээр бүргэгдэж дохиолол ирдэг.	0	10		
138	Ашиглалтын заавар	Генераторын холхивчны тосолгоог тодорхой хугацааны графикаар шинжилгээнд хамруулдаг.	0	10		
139	Ашиглалтын заавар	СЦҮ-ийн хурдны хайрцгийн тосыг тодорхой хугацааны графикаар шинжилгээнд хамруулдаг.	0	10		
140	Ашиглалтын заавар	Засвар үйлчилгээнд ашиглах багаж, төхөөрөмжүүд зориулалтын шаардлага хангасан, туршилт, тохируулга хийгдсэн.	0	10		
141	Ашиглалтын заавар	Таслах залгах аппарат, контактор, цахилгаан хэлхээ, шинүүд нь зориулалтын хаалт, хамгаалалттай байх бөгөөд хүн гараар авагдах боломжгүй байдлаар зохион байгуулсан.	0	10		
142	Ашиглалтын заавар	СЦҮ-ийн тоормозны систем нь аваарийн нөхцөлд болон аваарын зогсоох кнопоор найдвартай ажиллаж байх ёстой бөгөөд өөрийгөө өгөгдсөн хугацаанд тестелж ажиллагаа доголдсон үед хяналт удирдлагын системд мэдээлдэг.	0	10		
143	Ашиглалтын заавар	СЦҮ-ийн ашиглалтад үйлдвэрлэгчийн хяналт удирдлагын системийн ашиглалтын зааврыг мөрддөг.	0	10		
144	Ашиглалтын заавар	СЦС-ын ИТА нар нь тухайн СЦҮ-ийн төрөл, загварт тохирох үйлдвэрлэгчийн зааврууд болон холбогдох аюулгүй ажиллагааны дүрэм, журмуудтай танилцсан.	0	10		
145	Ашиглалтын заавар	СЦҮ дээр ажиллах ажилтан хязгаарлагдмал орчинд ажиллах сургалтанд хамрагдаж зөвшөөрөл авсан.	0	10		
146	Ашиглалтын заавар	СЦҮ-н ашиглалтын явцад түүний найдвартай ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн засвар, үйлчилгээг тогтмол хийдэг.	0	20		
147	Ашиглалтын заавар	СЦҮ-ийн засвар үйлчилгээнд ажиллах ажилтан нь өндөрт ажиллах зөвшөөрлийг тусгай сургалтанд хамрагдсан.	0	10		
Нарны цахилгаан үүсгүүрийн ашиглалт			0	80	0	0
148	Ашиглалтын заавар	Нарны дэлгэцийн ашиглалт, засвар үйлчилгээний график биелэгддэг.	0	20		

149	Ашиглалтын заавар	Цуваа холбогдсон нарны дэлгэцүүд ижил үзүүлэлт, чадалтай.	0	20		
150	Ашиглалтын заавар	Суурилагдсан нарны дэлгэцүүд дээрх засвар үйлчилгээг зөвхөн аюулгүй ажиллагааны шалгалт өгч эрх авсан тусгайлан сургагдсан, мэргэжлийн хүмүүс хийж гүйцэтгэдэг.	0	20		
151	Ашиглалтын заавар	Нэгтгэх хайрцагны засвар-үйлчилгээний ажлыг тусгайлан сургасан, мэргэжлийн хүмүүс гүйцэтгэдэг.	0	20		
НИЙТ ОНОО				2510		

БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар:

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар: